



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/71

Мандалговь

Г Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай  
зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.9, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.12.3, дэх заалт, эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох салбар комиссын 2018 оны 01 дугаар сарын 25-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагуудад тусгай зөвшөөрлийг хавсралтад зааснаар олгосугай.

Хоёр. Эрүүл мэндийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа MNS 5095:2017, Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS5203:2002, Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5260:2015 өөрсдийн үйл ажиллагаанд холбогдох бусад стандартын хэрэгжилтийг хангаж ажиллахыг эмнэлэг, эмийн сангийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан болон шинээр олгосон байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг тусгай зөвшөөрөл олгох салбар комисс /А.Нарантуяа /- т Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/, Эрүүл мэндийн газар /Г.Бат-Орших / нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  О.БАТ ЭРДЭНЭ

0200226

Аймгийн Засаг даргын 2018 оны 02 сарын 29  
 өдрийн захирамжын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА  
 ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ БАЙГУУЛЛАГЫН  
 НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

№	Үүсгэн байгуулагчийн нэр	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээн дугаар	Тусгай зөвшөөрлийн хугацаа	Хугацаа
1	"Моносфарм трейд" ХХК	"Монос" эм ханган нийлүүлэх	Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх	ХХ-11/10/964	3 жил	2017-10-28 2020-10-28
2	"Эдмонсфарм" ХХК	"Эдмонсфарм" эмийн сан	1-р зэрэглэлийн эмийн сан	ЭСХ-15/10/1033	3 жил	2017-12-09 2020-12-09
3	"Энгүүн далай" ХХК	"Энгүүн далай" шүдний эмнэлэг	Эрүү нүүрний зөвлөгөө өгөх, хиймэл шүдний эмнэлэг	ЭХ-14/10/974	3 жил	2017-12-30 2020-12-30
4	ОНӨААТҮГ	"Хулд" ЭЭСан	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	ЭСХ-15/10/1005	3 жил	2017-01-29 2020-01-29
5	"Дундговь аймгийн Нэгдсэн эмнэлэг"	Нэгдсэн эмнэлэг	Эмнэлэг, сувиллын бүх төрлийн мэргэжлийн үйл ажиллагаа	ЭУ-14/10/979	3 жил	2017-12-30 2020-12-30